


БАТЛАВ.

МОНГОЛБАНКНЫ ОЛОН
НИЙТИЙН САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН
ЗАХИРАЛ



Б.ОДОНТУНГАЛАГ

МОНГОЛБАНКНЫ НЭРЭМЖИТ ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Үндсэн мэдээлэл:

Энэ жил орчин цагийн мөнгөн тэмдэгт “Төгрөг”-ийг анх гүйлгээнд гаргасны 100 жилийн ой тохиолдуулан бага ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, мөнгөний үнэ цэнэ, хэрэглээний зөв дадалд суралцуулах зорилгоор гар зургийн уралдаан зарлаж байна.

Хоёр. Хамрах хүрээ:

- Эсээ бичлэгийн уралдааныг улс орон даяар зохион байгуулна.
- Бага ангийн сурагчид (1-5-р ангийн сурагчид)

Гурав. Сэдэв:

“Төгрөг – Миний нүдээр” (Оролцогчид төгрөгийн түүх, үнэ цэнэ, ирээдүйн хэрэглээ, хуримтлал, санхүүгийн боловсролтой холбоотой сэдвийг бүтээлдээ тусгаж болно.)

Дөрөв. Бүтээлд тавигдах шаардлага:

- Зургийг А3 эсвэл А4 хэмжээтэй цаасан дээр зурах
- Будах хэрэгсэлд хязгаарлалтгүй (тосон будаг, усан будаг, өнгийн харандаа гэх мэт)
- Бүтээлийн утга санааг нэг зурганд багтаасан байх,
- Уралдааны нэр агуулгад нийцсэн байх,
- Гар зураг нь өмнө нь ямар нэгэн уралдаанд оролцоогүй байх
- Бүтээл оролцогчийн өмч буюу өөрөө зурсан байх,
- Арын хэсэгт оролцогчийн нэр, нас, сургуулийн нэр, холбоо барих утасны дугаарыг тодорхой бичих,
- Арын хэсэгт бүтээлийн илэрхийлэх гэсэн санааг 1 өгүүлбэрт товчхон бичих.

Тав. Шалгаруулалт, үнэлгээний шалгуур:

Ерөнхий шаардлага	Оноо
Цаг баримтлал /18:00 цагаас хоцорсон бол -10 оноо/	10
Бүтээлд тавигдах шаардлагыг бүрэн хангасан эсэх	10
Сэдвийн илэрхийлэл	25
Уран бүтээлч шийдэл, өнгөний зохицол	25
Хувийн онцлог, бүтээлч байдал	15

Нарийвчлал, хийцийн чанар	15
Нийт	100

Зургаа.Шалгаруулалт:

Уралдааны дунг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр шалгаруулах бөгөөд шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, сошиал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

Шагнал:

- I байр: 800,000 төгрөг + Өргөмжлөл
- II байр: 600,000 төгрөг + Өргөмжлөл
- III байр: 400,000 төгрөг + Өргөмжлөл
- Тусгай байр (2 хүртэл): Мөнгөн шагнал + Өргөмжлөл

Бүтээл хүлээн авах хугацаа:

Бүтээлийг 2025 оны 05 дүгээр сарын 15-ны өдрийн 18.00 цаг хүртэл Монголбанкны төв байр болон орон нутаг дахь хэлтэс, салбарт хүлээн авна. Дэлгэрэнгүй мэдээллийг [mongolbank.mn](#), [www.mongolbank.mn](#) вэб хуудаснаас болон 11-311240 дугаарын утсаар лавлана уу.

ооо